



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Даланзадгадын дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон 7,081,000.00 (долоон сая наян нэгэн мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 1 ширхэг автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, "Даланзадгадын дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Л.Банзрагч нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Акталж, сэлбэгээр худалдсан автомашины улсын дугаарыг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг дээрх арга хэмжээний биелэлтийн хамт 2020 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



0000057

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн
48 дугаар тогтоолын хавсралт

"ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН
ЖАГСААЛТ

| Д/д | Автомашини марк, улсын дугаар, арал | Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он | Явсан км | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) | 2018 оны 619 дүгээр тогтоолоор |
|----------|---|-----------------------------------|----------|--------------------------------|--------------------------------|-------------------------|--------------------------------|
| 1 | КИА пронтер, 58-54 УБД, суудлын, KRHYAC3A2B030581 | 2002/2013 | 275,000 | 7,081,000.00 | 7,081,000.00 | - | 2,500,000.00 |
| Нийт дүн | | | | | | | |
| | | | | 7,081,000.00 | 7,081,000.00 | - | 2,500,000.00 |
| | | | | (долоон сая наян нэгэн мянган) | (долоон сая наян нэгэн мянган) | - | (хоёр сая таван зуун мянган) |